



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/94

Алтай хот

**Аймгийн "Тэргүүний хамт олон",
"Хөдөлмөрийн аварга"-ын шагналд
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.8 дахь хэсэг, 2.1.4, 2.1.8 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.4, 4.8 дахь хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэж, Коронавируст халдвар (КОВИД-19)-ийн цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр ханган үр дүнтэй зохион байгуулан ажилласан "Тэргүүний хамт олон", аймаг орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулж, хөдөлмөр, зүтгэл, ажлын амжилтаараа бусдыгаа манлайлан ажиллаж шалгарсан салбар салбарын "Хөдөлмөрийн аварга"-уудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Шагналд зарцуулагдах 2,900,000 (хоёр сая есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 23 ны өдрийн А/04 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН "ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОН"
"ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА"-ААР
ШАГНАГДАХ ИРГЭДИЙН НЭРС

№	Овог нэр	Шалгарсан салбар	Мөнгөн шагналын дүн
Тэргүүний хамт олон			
1.	Онцгой байдлын газар		500,000
Хөдөлмөрийн аварга			
2.	Намширын Нарантуяа	Боловсролын салбар	300,000
3.	Лхагвасүрэнгийн Наранжаргал	Боловсролын салбар	300,000
4.	Хоролын Мөнхбаатар	Эрүүл мэндийн салбар	300,000
5.	Содномын Саранцэцэг	Эрүүл мэндийн салбар	300,000
6.	Дашжамцийн Балжинням	Соёл, урлагийн салбар	300,000
7.	Эрдэнэсоёлын Ачитбаатар	Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах салбар	300,000
8.	Жадамбын Мөнхцэцэг	Төрийн захиргааны салбар	300,000
9.	Молын Баялагмаа	Худалдаа, үйлчилгээний салбар	300,000
Нийт дүн			2,900,000

__оОо__